

болгох асуудал оршсоор байна.

Дүгнэлт, санал.

Монгол улсын эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааны түүхэн уламжлалаас авч үзэхэд 1921 оноос одийг хүртлэх ер гаруй жилийн түүхэнд ялтныг хөдөлмөрлүүлэн цалин хөлс олгох асуудал тухай тухайн нийгмийн хөгжилтэй уялдаж явагдаж байлаа. Төрийн дээд байгууллагаас хорих байгууллагын талаар хэд хэдэн хууль, олон арван зарлиг, тогтоол гаргаж, тэдгээрийн хэрэгжилтийн явцад уг байгууллагын үйл ажиллагааны явцад цалин хөлс олгох асуудал улам боловсронгуй болон хөгжих шаардлага үргэн гарч ирсэн юм.

Монгол улсад хорих ял эдлэж байгаа ялтны цалин хөлс нь Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн актаар зохицуулагдаж байна.

Хөдөлмөр эрхэлж буй ялтанд шагналын хоног олгох, хөдөлмөрийн хөлс бодохоос гадна нийгмийн даатгалд хамруулж цаашид тэтгэвэр авах боломжийг бүрдүүлэх нийгмийн шаардлагын хэрэгцээг хангах нь зүйтэй. Энэ нь нэг талаас тухайн ялтан суллагдан гарахад нийгмийн баталгаа болох зайлшгүй хэрэгцээ юм.

Нөгөөтэйгүүр ялтны хөдөлмөрт хандах хандлага нь тэдгээрт олгож байгаа цалин хөлснөөс шууд шалтгаалдаг тул түүнийг боловсронгуй болгоход тэдгээрийн ажил гүйцэтгэх чадвар, мэргэжил дадлагыг харьцуулан үзэх нь зайлшгүй байна.

Иймд доорх саналыг дэвшүүлж байна.

1. Ялтанд мэргэжил эзэмшүүлэх ажлыг эрчимжүүлэн гэрээгээр ажлуулах явцад хөдөлмөрийн хөлсийг нэмэгдүүлэх тал дээр харгалзан үзэх
2. Хорих ангийн аж ахуй үйлчилгээнд ажиллаж байгаа зарим нэг ялтнуудтай нагийн хөдөлмөр хийлгэх талаар гэрээ байгуулан ажиллах
3. Ажил хөдөлмөр хийж байгаа ялтнуудаас холбогдох татварыг авч хэвшүүлэх
4. Хөдөлмөрт хамрагдаж байгаа ялтнуудыг нийгмийн даатгалд хамруулан зохих шимэтгэлийг толүүлэн даатгалд хамруулах
5. Ялтны цалин хөлсийг ялгамжтай бодож олгон тэдний зүгээс хөдөлмөрт хандах хандлагыг идэвхжүүлэх



О.БАТСАЙХАН
Хууль сахиулахын
их сургуулийн
Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
сургуулийн
Шийдвэр
гүйцэтгэлийн
процессын эрх зүйн
тэнхимийн ахлах
багш, хөшууч

ЯЛТНЫГ СУЛЛАХАД БЭЛТГЭХ АЖИЛЛАГААНД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Хорих байгууллагаас ялтныг хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх, суллагдаж буй этгээдийг нийгмийн харилцааны тогтолцоо, улмаар бичил болон өргөн хүрээнд харьцах харьцаанд анхаарч, алдаа эндэгдлийг нь засаж сайжруулахыг оноогийн нийгэм шаардаж байна. Нийгмийн энэхүү байдлыг ялтан дангаараа давж гарах боломжгүй юм.

Гэвч шоронд ял эдлэгсдийг суллахад зохих хэмжээгээр бэлтгэх ажил нь нийгэм, гэр бүлд, хүмүүстэй харьцах харьцаа, сэтгэл зүйн, зан байдлын төлөвшил хангагдсан, хуулийн хүрээнд амьдрахад бэлтгэгдсэн гэхээсээ илүүтэйгээр, мэргэжил эзэмшүүлэх, сурах, мэдээллээр хангах төдийгөөр явуулж, бодит нөлөөлөл болж чадахгүй байгаа нь дахин гэмт хэрэг үйлдэгдэхийг багасгахгүйд хүргэж байгаа юм. Нөгөөтэйгүүр хувь хүнийхээ үүднээ нийгэмд /стереотип/ хэвшил болсо байж болох ялтны зан төлөвийг нээ чадахгүй байгаа байдал нь хэвий ажиллаж амьдрахад сөргөөр нөлөөл



зэрэг байдлууд гарч байна. Иймээс дээрхи чиг хандлага, арга барил, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байна. Өнөөдөр хорих ангид нийгмийн ажилтнууд ХЗДХ-ийн сайдын 2009 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 198 тоот /Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөр батлах тухай/

ШШГЕГ-ын даргын 2009 оны 10 сарын 14 өдрийн А/91 тоот “Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай”

ШШГЕГ-ын даргын 2008 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/106 дугаар “Хорих анги, ШГА-ны сэтгэл зүйчийн ажлын заавар батлах тухай”

ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 дугаар сарын 10-ний өдрийн А/107 дугаар “Хорих ангийн нийгмийн ажлын заавар батлах тухай” тушаал эрх зүйн актыг үндэслэн ялтныг суллахад бэлтгэх ажил явуулж байна. Үүнд: Суллагдах дөхсөн ялтны нийгмийн сэтгэл зүйн нөхөн сэргээх олон талт ажлыг зохион байгуулах. /бичиг баримтжуулах, ажилд зуучлах асуудлыг зохих газруудад нь холбох гэх мэт/

Ялтны сэтгэл зүйг нөхөн сэргээх ажилд мэргэжлийн болон сайн дурын байгууллагатай хамтран ажиллаж болно. гэж ерөнхий байдлаар тусгасан байна.

Санал асуулга, ярилцлагын хүрээнд: “Хорих ял эдлэгсдийг суллахад бэлтгэх ажлын үр нөлөө судалгааны ажлын явцад цуглуулсан мэдээлэлээс авч үзэхэд хорих 413 дугаар ангид хорих ял эдлэгсдэд төдийлөн сайнаар нөлөөлөхгүй байна. Тус ангид 2010 оноос 2013 оны нэгдүгээр улирал хүртэлх хугацаанд:

2010 онд 435 ялтнаас 234 ялтан давтан 56,3 %, 2011 онд 433 ялтнаас 236 ялтан давтан 54,5 %, 2012 онд 432 ялтнаас 268 ялтан давтан 62%, 2013 онд 429 ялтнаас 239 ялтан давтан 55.7% байгаагаас харахад: дунджаар 57,12% нь дахин давтан гэмт хэрэг үйлдсэн ялтнууд байна.

Суллагдахын өмнөх сургалтанд хамрагдсан байдлыг үзэхэд 2010 онд 14 ялтанд сургалт явуулсан ба 65 ялтан суллагдсан, 2011 онд 31 ялтанд сургалт явуулснаас 56 ялтан суллагдсан, 2012 онд 44 ялтанд сургалт явуулснаас 33 ялтан суллагдсан, 2013 оны эхний 9 сарын байдлаар 44 ялтанг сургалтанд хамруулж, 30 ялтан суллагдсан байна. Нийт сүүлийн 4 жилийн байдлаар 187 ялтан суллагдсан ба, 133 ялтан сургалтанд хамрагдсан байгаа нь суллагдагсдын 71,1%-ийг эзэлж байна.

Санал асуулгаас үзэхэд суллахад бэлтгэх ажлын талаар авч буй арга хэмжээ, түүний үр нөлөө, хэрэгжүүлж буй ажилтны мэдлэг, туршлагыг дээшлүүлэх хэрэгтэй байгаа юм. Хорих ял эдлэгсдийг суллахад бэлтгэх ажиллагааг боловсронгуй болгох нь суллагдсаны дараа хэрхэн аж төрөхөө хайх, нийгэмд дасан зохицохыг эрэлхийлэх биш, нийгэмд амьдралын зөв хэвшлээ богино хугацаанд олох боломжийг тодорхойлох явдал юм. Өнөөгийн нөхцөлд хорих ял эдлэгсдийг суллахад бэлтгэхэд:

1. Хорих ангид нийгмийн ажилтан ярилцлага хийх, гаднах орчинг хүртээмжгүй ойлгуулах,
2. Төдийлэн тулж ажилладаггүй байгаа байдал.
3. Суллагдсаны дараах хамгийн

чухал асуудал юу болохыг ойлгуулах асуудал нийтлэг учир дутагдалтай байна.

Гадаадын зарим эрдэмтэн, судлаачдын бичсэнийг²⁷ үзвэл зарим орны хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлэх нь нийгмийн хөгжлийн үе шатуудад тухай бүр зохицсон байдлаар хөгжиж, төлөвшиж ирсэн байна. Герман улс шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүйн системдээ цоо шинэ өөрчлөлт хийж, хүний эрхийг баталгаажуулсан стандартыг хүлээн зовшоорч, тодорхой үр дүнд хүрсэн байна. Монгол Улс хуулийн салбарт хийж буй зарим шинэчлэл, өөрчлөлтийг олон улсын стандартад нийцүүлэх зорилтын хүрээнд зарим улсын сайн туриллагыг авах, бодитой ажлыг цаг алдалгүй хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Ял эдлэгсдийг нийгэмшүүлэх ажлыг эрчимтэй хөгжүүлсэн зарим улсуудад:

- Тусгайлсан хууль гаргах /Prison Act эсвэл Prison code/

- Хүний нөөцийг шинэ нөхцөлд ажиллах бэлтгэлийг хангах зэрэг цогц арга хэмжээ хэрэгжүүлсэн байна. Тухайлбал: Германы шийдвэр гүйцэтгэлийн хууль тогтоомж нь хорихоос суллагдах бэлтгэл ажлыг хэрхэн хангах талаар хуульчилж, хорихын дэглэмийг зөөлрүүлж болох ба суллагдахаас гурван сарын өмнө 7 хоногийн чөлөө олгох, мөн хорих байгууллагаас гадуур чөлөөтэй явах эрхтэй хоригдолд сар бүр 6 хоногийн чөлөө олгодог. Суллагдахаас нь 6-9 сарын өмнө хоригдлыг хагас чөлөөт

байдалтай хорих ангид ирүүлдэг ба суллагдсаны дараа хийх ажлаа хайж олохоор ажилладаг. Нэг өрөөнд 1-3 хүн байрлана. Хоригдол ар гэрийнхэн болон танил талтайгаа уулзаж тэднийг байрандаа хүлээн авах бололцоотой бөгөөд үүнд хөндлөнгийн ямар нэгэн хяналт шалгалт тавигддаггүй. Чөлөөт цагаараа захиргаанаас чөлөө авч гадуур явж болох бөгөөд энэ нь 22 цаг 30 минут хүртэл зөвшөөрөгддөг. Мөн хүмүүжлийн ажил нь хэсэг бүлгээр нь зохиох ярилцлага бөгөөд үүнийг нийгмийн ажилтан, эсхүл сэтгэл зүйч долоо хоногт хэд хэдэн удаа зохион байгуулдаг. Нийгмийн ажилтны тоо багш, эмч, сэтгэл зүйчийн тооноос 2,5 дахин, санваартнуудын тооноос 4 дахин илүү байхаар зохицуулагдсан байна. Германы хорих байгууллагын нийгмийн ажлын зохион байгуулалтад хэд хэдэн онцлог байдаг. Тухайлбал, шашны үүрэг мэдэгдэхүйц, хорих байгууллага бүрт католик юмуу протестант шашны санваартнууд хоригдлуудтай ажилладаг ба бүр суллагдсаны дараа нь хүртэл холбоотой байдаг байна. Сүүлийн үед телевизийн тусламжтайгаар дээд боловсролыг эчнээ эзэмших бололцоотой болжээ. Германд харьцангуй хөнгөн гэмт хэрэгт яллагдсан болон цөөн жилтэй хүмүүс, мөн суллагдах хоригдлуудыг нийгэмд дасгаж байх зорилгоор суллагдахаас нь нэг жилийн өмнө байрлуулдаг “нээлттэй” хэсэг зарим ангид байдаг, мөн бие даасан ийм анги ч байдаг байна. Ийм газарт цонх нь торгүй, гал тогоондоо хоол ундаа өөрсдөө бэлтгэдэг, жирийн байдлаар хувцаслаж болох, мөн утсаар ар гэр, ойр дотныхоо хүмүүс рүү

²⁷ Dirk Van Zyl Smit, Frieder Dunkel, / 2011/ "Imprisonment today and tomorrow: international perspectives on prisoners' rights and prison conditions



ярьж болдог, 7 хоногт нэг удаа гэртээ харьдаг хэлбэр нэлээд түгээмэл байдаг. Хоригдол хэдийчинээ нарийн мэргэжил эзэмших нь суллагдсаны дараа ажил олох, амжилттай хөдөлмөрлөхөд дөхөмтэй гэдгийг нийгмийн ажилтнууд бодолцожээ. Суллагдсан хүмүүсийн 40 хувь нь эхний 5 жилд ямар нэгэн хэмжээгээр хууль давтан зөрчдөггүй гэсэн тооцоо гарсан нь германы хорих ангийн ажлын амжилт гэж үздэг байна. Ялтныг суллахад бэлтгэх ажлын үр нөлөөг дээшлүүлэхдээ дараах байдлаар шийдвэрлэжээ. Үүнд: Ялтныг нийгэмшүүлэх ажлыг тусгайлсан хуулиар зохицуулж байгаа улс байхад, хөтөлбөр гарган хэрэгжүүлж байгаа жишиг ч байна. Ял эдлэж байгаа хүмүүсийг нийгэмд дасан зохицоход нь туслалцаа дэмжлэг үзүүлэх ажил нь нийгмийн үйлчилгээний нэг төрөл бөгөөд²⁸ үүнийг зарим орны туршлагаас үзэхэд төрийн аль нэг институтаар гүйцэтгүүлдэг ч байна.²⁹

Ялтныг суллахад бэлтгэх талаар судлагдсан улс орнуудад

Probation, Parol буюу тусгайлсан алба, ажилтан хяналт тавьж, дэмжлэг үзүүлэн ажиллах.³⁰

Тусгайлсан хөтөлбөр гарган ажиллах гэсэн тогтсон хандлага байна.

²⁸ Шоронгоос суллагдах хүмүүсийг нийгэмшихэд нь туслалцаа дэмжлэг үзүүлэх ойлголтыг гадаадын зарим оронд нийтлэг байдлаар "resocialization эсвэл reintegration and rehabilitation of criminal offender" хэмээн томъёолдог бөгөөд тусгайлсан институтууд энэхүү үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэх үүрэгтэй байна.

²⁹ Тухайлбал: Англи улсад The rehabilitation of offender act -1974 гэсэн хууль үйлчилдэг бөгөөд түүнд заасан арга хэрэгслээр шоронд байгаа болон суллагдсан хүмүүст нийгмийн ажил, үйлчилгээ үзүүлэх хугацаа зэргийг зохицуулсан байдаг.

Илтгэлийн хүрээнд гаргах санал, зөвлөмж

Хорих ангид ялтныг суллахад бэлтгэх ажлыг явуулахад дараах бүлэг асуудлыг анхаарах. Үүнд:

Нэг. Олон нийтээс тусгаарлагдсан, хязгаарлагдмал нөхцөлд ял эдлэж буй эдгээр хүмүүсийн сэтгэл зүйн онцлог, өөрчлөлт, дасан зохицол, айдас түгшүүр, залхсан, хэн нэгэнд өширхсөн, гомдсон зэрэг зан араншингийн өөрчлөлт зэргийг судлаж, дэмжлэг үзүүлдэг байх шаардлагатай байна. Иймээс хорих ял эдлэгсдийг суллахад бэлтгэх ажлыг үр өгөөжтэй явуулахад судалгаа, шинжилгээг чиглүүлж тусгайлсан судалгааны төв бий болгох,

Хоёр. Нийгмийн амьдралд дасан зохицох бололцоог хангах ажлыг зохион байгуулж /дэглэм харгалзахгүй, гадуур ажилд хамруулах/ үүнд аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах, тэдгээрийг урамшуулах санхүүгийн болон бусад арга хөшүүргийг олох. Тухайлбал: ХБНГУ-улс хорих ангид суллагдахаас өмнөх жилийн хугацаанд хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан хорих байгууллагаас гадуур хөдөлмөр эрхлүүлдэг туршлагыг харгалзах.

Гурав. Суллахад бэлтгэхэд олон нийтийн ба төрийн болон төрийн бус байгууллага яаж оролцох нь тодорхой биш тул журмаар зохицуулж өгөх нь зүйтэй